ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код:** ДГА-2024/09/НА-СТА-ТШ3

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг

2024 он


Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Энхтөр

Цахим хаяг:ij17.audit@gmail.com


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.Аудитын санал дүгнэлт

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2024.02.23 № 1-6/100

танай______________-ны №______________-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН ДАРГА Д.ЦЭНДМАА ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

### Аудитын гол асуудал

Тайлант онд тус байгууллага нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 988.5 сая төгрөгийн авлагатай бөгөөд насжилтын тайлан гаргаагүй, тооцоо нийлж баталгаажуулсан баримт байхгүй, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шилэн дансны сайтад хуулийн 6.4.4. Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авалтын мэдээлэл болох 4,714.4 сая төгрөгийн 271 мэдээлэл байршуулахаас 3,802.7 сая төгрөгийн 212 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ" гэсэн заалттай нийцэхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

| | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 1,842,343,586.94 | 2,115,352,084.61 |
| 33 | Авлага | 1,842,343,586.94 | 2,115,352,084.61 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 412,927,103.55 | 490,223,527.55 |
| 33700 | Хөтөлбөртэй холбоотой авлага | 1,429,146,778.39 | 1,624,858,852.06 |
| 33703 | Хувиараа хөдөлмөр эрхлэгч, нөхөрлөл, хоршоо байгуулах иргэнийг дэмжих | 682,015,004.00 | 874,843,624.00 |
| 33705 | Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | 122,235,450.00 | 134,129,068.00 |
| 33706 | Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | 256,919,524.94 | 250,597,424.94 |
| 33717 | Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ | 97,637,999.45 | 130,791,694.45 |
| 33720 | Аймаг, нийслэл, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөс дэмжсэн орон нутгийн онцлогтой төсөл | 49,990,000.00 | 49,990,000.00 |
| 33718 | Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих | 211,188,800.00 | 175,347,040.67 |
| 33730 | Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр | 9,160,000.00 | 9,160,000.00 |
| 33500 | Бусад авлага | 269,705.00 | 269,705.00 |
| 33520 | Хувь хүмүүсээс авах авлага | 269,705.00 | 269,705.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | - | - |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН | 1,842,343,586.94 | 2,115,352,084.61 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | - |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,842,343,586.94 | 2,115,352,084.61 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | - | - |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 1,842,343,586.94 | 2,115,352,084.61 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,085,296,271.94 | 1,842,343,586.94 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 757,047,315.00 | 273,008,497.67 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,842,343,586.94 | 2,115,352,084.61 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

| | Үзүүлэлт | Өмнөх үе | Тайлант үе |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 1,506,057,600.00 | 1,531,624,000.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 140,973,000.00 | 280,130,000.00 |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | 140,973,000.00 | 280,130,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 140,973,000.00 | 280,130,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 140,973,000.00 | 280,130,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 10,365,084,600.00 | 1,251,494,000.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | - | 1,251,494,000.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | - | 1,251,494,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,365,084,600.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,365,084,600.00 | - |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 749,010,285.00 | 660,620,509.86 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 749,010,285.00 | 660,620,509.86 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,900,000.00 | 640,638,709.86 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,900,000.00 | 840,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,900,000.00 | 840,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 745,110,285.00 | 19,981,800.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 55,845,482.00 | |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 55,845,482.00 | |
| 2135 | Төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 249,917,624.00 | 19,981,800.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 249,917,624.00 | 19,981,800.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 439,347,179.00 | - |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 439,347,179.00 | - |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН | 757,047,315.00 | 273,008,497.67 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | - | - |
| 5 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | - | - |
| 5 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН | 757,047,315.00 | 273,008,497.67 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

| | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 1,518,739,303.55 | 1,789,243,571.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 153,654,703.55 | 537,749,571.00 |
| 1200 | Нийтлэг татварын бус орлого | 153,654,703.55 | 537,749,571.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 153,654,703.55 | 537,749,571.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 140,973,000.00 | 280,130,000.00 |
| 1200043 | Урд оны үлдэгдлээс санхүүжих | 12,681,703.55 | 257,619,571.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,365,084,600.00 | 1,251,494,000.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | - | 1,251,494,000.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | - | 1,251,494,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,365,084,600.00 | - |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,365,084,600.00 | - |
| 14 | Үйл ажиллагааны бус орлого | 313,896,585.00 | 435,187,926.33 |
| 131104 | Бусад орлого | 313,896,585.00 | 435,187,926.33 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,832,635,888.55 | 2,224,431,497.33 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 1,832,635,888.55 | 2,224,431,497.33 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,900,000.00 | 68,001,700.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,900,000.00 | 68,001,700.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,900,000.00 | 68,001,700.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 1,828,735,888.55 | 2,156,429,797.33 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 140,973,000.00 | 537,749,571.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 140,973,000.00 | 537,749,571.00 |
| 2134 | Орон нутгийн төсвөөс ерөнхийлөн захирагчид олгох татаас, санхүүжилт | 263,820,624.55 | 218,452,160.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 12,681,703.55 | 218,452,160.00 |
| 213405 | Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 251,138,921.00 | |
| 2135 | Төсвийн захирагчаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 313,896,585.00 | 435,187,926.33 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 313,896,585.00 | 435,187,926.33 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 1,110,045,679.00 | 965,040,140.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 1,110,045,679.00 | 965,040,140.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | (313,896,585.00) | (435,187,926.33) |
| 9 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 313,896,585.00 | 435,187,926.33 |
| 145004 | Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх | 313,896,585.00 | 435,187,926.33 |
| 10 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | - | - |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 313,896,585.00 | 435,187,926.33 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | |
| 11 | МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ | - | - |
| 12 | МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

төгрөгөөр

| Үзүүлэлт | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|
| 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,085,296,271.94 | 1,085,296,271.94 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,085,296,271.94 | 1,085,296,271.94 |
| Тайлант үеийн үр дүн | 757,047,315.00 | 757,047,315.00 |
| 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 1,842,343,586.94 | 1,842,343,586.94 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 1,842,343,586.94 | 1,842,343,586.94 |
| Тайлант үеийн үр дүн | 273,008,497.67 | 273,008,497.67 |
| 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,115,352,084.61 | 2,115,352,084.61 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
|---|---|---|---|
| Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого | 1,381,364,000.00 | 2,224,431,497.33 | 161 |
| ХБИ ажиллуулаагүйн төлбөрийн орлого | 130,000,000.00 | 280,130,000.00 | 215 |
| Өмнөх оны үлдэгдэл | - | 257,619,571.00 | |
| ХЭД сангаас хуваарилсан санхүүжилт | 1,251,364,000.00 | 1,251,494,000.00 | 100 |
| Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт | - | 435,187,926.33 | |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,381,364,000.00 | 2,224,431,497.33 | 161 |
| Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хэрэгжүүлэх | 36,800,000.00 | 25,611,390.00 | 70 |
| Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ | 17,000,000.00 | 16,930,300.00 | 100 |
| Ажилд зуучлах үйлчилгээ | 19,800,000.00 | 8,681,090.00 | 44 |
| Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэх | 1,214,564,000.00 | 1,007,430,450.00 | 83 |
| Хөдөлмөрт бэлтгэх сургалт | 36,295,000.00 | 28,318,200.00 | 78 |
| Суурь чадварын сургалт | 3,000,000.00 | 3,000,000.00 | 100 |
| Танхимын болон үйлдвэрлэл дээрх мэргэжлийн сургалт | 20,520,000.00 | 14,043,200.00 | 68 |
| Аж ахуй эрхлэлтийн сургалт | 3,575,000.00 | 2,075,000.00 | 58 |
| Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийн үйлчилгээг мэргэжлийн талуудтай хамтран зохион байгуулах | 4,800,000.00 | 4,800,000.00 | 100 |
| Эмэгтэйчүүдэд зориулсан богино хугацааны ур чадвар олгох болон гэрээс зайнаас ажиллахыг дэмжих сургалт | 4,400,000.00 | 4,400,000.00 | 100 |
| Аж ахуй эрхлэлтийг дэмжих санхүүгийн дэмжлэг | 654,720,000.00 | 587,140,000.00 | 90 |

| | | | |
|---|---|---|---|
| Иргэн, аж ахуйн нэгжид санхүүгийн дэмжлэг олгох | 400,000,000.00 | 368,900,000.00 | 92 |
| Малчдын малжуулах | 100,000,000.00 | 90,000,000.00 | 90 |
| Шилдэг Старт-Ап залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох | 18,000,000.00 | 16,000,000.00 | 89 |
| Ахмадын санхүүгийн дэмжлэг | 100,000,000.00 | 100,000,000.00 | 100 |
| Ажил олгогчийг дэмжих | 15,120,000.00 | 5,040,000.00 | 33 |
| Түрээсийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээ | 21,600,000.00 | 7,200,000.00 | 33 |
| Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр | 165,431,000.00 | 156,612,800.00 | 95 |
| Санхүүгийн дэмжлэг | 145,055,000.00 | 144,985,000.00 | 100 |
| Борлуулалтын болон ажлын байрны түрээсийн төлбөрт дэмжлэг үзүүлэх | 10,800,000.00 | 9,600,000.00 | 89 |
| Хөгжлийн бэрхшээлтэй хүнд ажлын байр бий болгосон ажил олгогчид дэмжлэг үзүүлэх | 5,040,000.00 | - | - |
| Хөдөлмөр эрхлэлтийн сургалт зохион байгуулах | 4,536,000.00 | 2,027,800.00 | 45 |
| Түр ажлын байрыг дэмжих арга хэмжээ | 268,640,000.00 | 162,687,750.00 | 61 |
| Мод тарих | 200,000,000.00 | 104,403,750.00 | 52 |
| Нийтийг хамарсан ажил зохион байгуулах | 60,000,000.00 | 53,964,000.00 | 90 |
| Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ | 8,640,000.00 | 4,320,000.00 | 50 |
| Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа | 89,478,000.00 | 72,671,700.00 | 81 |
| Хөдөлмөрийн тухай хуулийн болон Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хуулийн хэрэгжилтийг хангах | 7,000,000.00 | 7,000,000.00 | 100 |
| Хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл мэдээллийн нэгдсэн сан үүсгэх, мэдээллийн системийг сайжруулах, шинэчлэх | 8,000,000.00 | 5,924,000.00 | 74 |
| Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага ажилтнуудын чадавхи бэхжүүлэх сургалт, зөвлөгөөн зохион байгуулах | 10,000,000.00 | 9,981,500.00 | 100 |
| Хөдөлмөр эрхлэлтийг сурталчилах, олон нийтийг соён гэгээрүүлэх арга хэмжээ, | 15,000,000.00 | 9,219,200.00 | 61 |
| Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд дүн шинжилгээ, хяналт, үнэлгээ хийлгэх | 10,978,000.00 | 5,891,000.00 | 54 |
| Хөдөлмөр эрхлэлт, хөдөлмөрийн зах зээлийн судалгаа | 25,000,000.00 | 25,000,000.00 | 100 |
| Гарын авлага, маягт, хэвлэмэл материалын эх бэлтгэх, хэвлүүлэх | 4,000,000.00 | 4,000,000.00 | 100 |
| Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, аймаг, нийслэл, дүүргийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжих | 4,500,000.00 | 2,340,000.00 | 52 |
| Хөдөлмөрийн хүрээний суурь зарчим, үндсэн хэрэгжилтийг хангах | 5,000,000.00 | 3,316,000.00 | 66 |
| ТӨВЛӨРҮҮЛЭЛТ | 130,000,000.00 | 1,191,389,657.33 | 916 |
| Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт ХЭДСан | - | 403,974,091.33 | |
| Санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт Сангийн яам | - | 31,213,835.00 | |
| ХБИ ажиллуулаагүйн эргэн төлөлт ХЭДСан | 130,000,000.00 | 194,880,000.00 | 150 |
| ХБИ ажиллуулаагүйн эргэн төлөлт Сангийн яам | - | 85,250,000.00 | |
| Санхүүжилтийн буаалт Сангийн яам | - | 218,452,160.00 | |
| Урд оны үлдэгдэл ХЭДСан | - | 257,619,571.00 | |
| ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ | - | - | |

## 3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1 алдаа зөрчил илэрснээс, 1 зөвлөмж өгсөн.

## 4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Тайлант онд үүссэн өглөгийг барагдуулах | 1 | - | - | - | 1 | - | - | - | - | - |
| Дүн | **1** | **-** | **-** | **-** | **1** | **-** | **-** | **-** | **-** | **-** |

## 5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан.

Шилэн дансанд мэдээллийг иж бүрэн, үнэн зөв, хугацаанд нь мэдээлээгүй болон бусад холбогдох хууль, дүрэм журам зөрчсөн 3,802,651.7 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх талаар 1 албан шаардлага хүргүүлсэн.

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан | 1 | 3,802,651.7 | - | - | 1 | 3,802,651.7 | - | - |
| **Дүн** | **1** | **3,802,651.7** | **-** | **-** | **1** | **3,802,651.7** | **-** | **-** |